



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 453

Улаанбаатар хот

“Ундрах актив” ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох,
төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх
үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15.1, Хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батласан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ундрах актив” ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Тус ХЗХ-нд төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрсүгэй.
3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Ундрах актив” ХЗХ /Д.Чулуунцэцэг/-нд үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000455